



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/02/-НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2024 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: <a href="mailto:gunjidmaag@audit.gov.mn">gunjidmaag@audit.gov.mn</a> Аудитын менежер: Утас: 99175677 Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a> Ахлах аудитор/аудитор: Б.Цэцэгмаа Утас: 99488754 Цахим хаяг: <a href="mailto:tsetsegmaab@audit.gov.mn">tsetsegmaab@audit.gov.mn</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГАА-2022/01/-НА-СТА-ТТЗ



БЯАН-УУЛ СУМЫН ЗАСАГ  
ДАРГА Э.НЯМБААТАР  
ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.25 № 132

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Баян-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Баян-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 20.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн, малын тоо, толгойн албан татварын орлого болох 28.8 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлээгүй нийт 49.6 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 41 дүгээр зүйлийн 41.2.1, 60 дугаар зүйлийн 60.2.8 дахь заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын Сангийн яамны 2024 оны 02 дугаар сарын 6-ны өдрийн 10/683 тоот албан бичгийн хавсралтаар Төсвийн тухай хуулийн дагуу 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах чиглэлийг ирүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,779.1 сая төгрөг буюу 89 хувьтай байна. Энэ нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг төлөвлөснөөс 113.0 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

0702900421

## Бусад асуудлын хэсэг

Баян-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 5 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 111 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 84.1 гэж дүгнэсэн байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Баян-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган. төгрөг/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>		
Эргэлтийн хөрөнгийн дүн	717,157.9	827,740.7
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,190,779.4	1,428,712.1
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>1,907,937.3</b>	<b>2,256,452.8</b>
Нийт өр төлбөрийн дүн	1,596.7	-
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,906,340.6	2,256,452.8
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,907,937.3</b>	<b>2,256,452.8</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>		
Үйл ажиллагааны орлогын дүн	2,456,925.4	2,019,076.1
Үйл ажиллагааны зардлын дүн	1,786,260.7	1,740,938.3
<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>670,664.7</b>	<b>278,137.8</b>
Үйл ажиллагааны бус зардлын дүн	6,171,602.5	(71,974.4)
<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>(5,500,937.8)</b>	<b>350,112.2</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>		
Өмчид гарсан өөрчлөлт	7,552,594.3	1,906,340.6
Тайлант оны үр дүн	(5,500,937.8)	350,112.2
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(145,315.9)	
<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>1,906,340.6</b>	<b>2,256,452.8</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,004,072.0	1,903,038.2
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,690,750.0	1,579,306.6
Үйл ажиллагааны ЦМГ	313,322.0	323,731.5
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(350,180.9)	(186,593.7)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	(30,000.0)	(87,000.0)
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(66,858.9)	50,137.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	272,580.4	205,721.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	205,721.5	255,859.3
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>		
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>1,108,199.1</b>	<b>1,779,098.2</b>
Урсгал зардал	739,574.1	1,523,209.3
Хөрөнгийн зардал	338,624.9	168,888.9
<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>1,100,230.1</b>	<b>1,782,884.7</b>
Орон нутгийн төсвөөс	1,024,889.2	1,715,270.5
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	75,340.8	67,614.1

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

Баян-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагч, нэгтгэгддэг нэгж байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар 53,767.4 мянган төгрөгийн 5 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитаар залруулсан.

Аудитаар нийт 49,596.7 мянган төгрөгийн 10 зөрчил илрүүлснээс 34,803.7 мянган төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 14,793.0 мянган төгрөгийн 6 зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн байна.

**Харьяа байгууллагууд**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сан, 4 байгууллагын (Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв) тогтмол зардал нэгтгэсэн байна.

Аудитаар ЗДТГ-ын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн ба сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх барьцаа хөрөнгийн сан, Орон нутгийн хөгжлийн сан, Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлыг аудитын түүвэрт хамруулсан.

**Түүвэрт хамрагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх барьцаа хөрөнгийн сан, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил**

Аудитаар санхүүгийн тайланд буруу тусган илэрхийлсэн 14,753.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 4,333.3 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

**Аудитаар Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил**

Аудитаар санхүүгийн тайланд буруу тусган илэрхийлсэн 39,013.8 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 60,371.9 мянган төгрөгийн 10 зөрчил илрүүлж 1,666.1 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 58,705.8 мянган төгрөгийн 8 зөрчил арилгах, давтан гаргахгүй албан шаардлага хүргүүлсэн байна.

**Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 28,804.3 мянган төгрөгийн 2 зөрчил илрүүлснээс 28,804.3 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож 1 заалт зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн байна.

**Албан шаардлага**

Малын тоо, толгойн албан татварын орлого 28,804.3 мянган төгрөгийг ОНХС-д төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д "Малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх,

<sup>1</sup> Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/, *эвь-Алтэй аймаг дэхь*

байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна." гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Малын тоо толгойн албан татварын орлогыг орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

2.Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 20,792.4 мянган төгрөгийн зөрчил илэрч, 5,999.4 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 14,793.0 мянган төгрөгийн 5 зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх албан шаардлагыг холбогдох байгууллагад хүргүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37-д ""төсвийн төвлөрүүлэн захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг", 5 дугаар зүйлийн 5.1-д "Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална: 5.1.3 санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.6.1-д "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх", Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-т "Агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нэгжийнхээ өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, үр дүнг агентлагийн даргын өмнө хариуцна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих санхүүгийн дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Баян-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллэйн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан				Залруулаагүй	
	Тоо	Дун	Тоо	Дун	Тоо	Дун	Тоо	Дун	Залруулсан		Залруулаагүй	
									Тоо	Дун	Тоо	Дун
Баян-Уул сумын Засаг даргын Тамгын газар	2	39,013.80			2	39,013.80	2	39,013.80				
Баян-Уул сумын Хоршоо хөгжүүлэх сан	2	14,753.60			2	14,753.60	2	14,753.60				
<b>Дун</b>	<b>4</b>	<b>53,767.40</b>		-	<b>4</b>	<b>53,767.40</b>	<b>4</b>	<b>53,767.40</b>				

/мянган төгрөгөөр/

Баян-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/

	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:			
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн
Аудитад хамрагдсан байгууллагын нэр						
Баян-Уул сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч	2	28,804.30	1	28,804.30	1	-
Баян-Уул сумын Засаг даргын Тамгын газар	7	16,459.10	2	1,666.10	5.00	14,793.00
Баян-Уул сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	4,333.30	1	4,333.30	-	-
<b>Дүн</b>	<b>10.00</b>	<b>49,596.70</b>	<b>4.00</b>	<b>34,803.70</b>	<b>6.00</b>	<b>14,793.00</b>

Нийцлийн асуудлаар илэрсэн зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/

	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:			
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн
Аудитад хамрагдсан байгууллагын нэр						
Баян-Уул сумын Засаг даргын Тамгын газар	3	43,912.80	-	-	3	43,912.80
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>43,912.80</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>43,912.80</b>

Баян-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо						Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан		
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй						
A	1	2	3	4	5	7	8	9	10		
1	Баян-Уул сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч	1	1	-	-	-	1	-	-		
2	Баян-Уул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1	-	1	-	-	-	-	-		
3	Баян-Уул сумын Засаг даргын Тамгын газар	1	1	-	-	-	1	-	-		
4	Баян-Уул сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	-	1	-	-	-	-	-		
5	Баян-Уул сумын Орон нутгийн хөгжлийн сан	1	-	1	-	-	-	-	-		
6	Баян-Уул сумын Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан	1	-	1	-	-	-	-	-		
	НИЙТ	6	2	4	-	-	2	-	-		